БАТЛАВ:
БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН
ТУХАЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ГАЗРЫН ДАРГА

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

ӨНӨД ТҮНШ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЦЭНДСҮРЭН

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН НУТАГТ ОРШИХ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ____________
ТУХАЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ӨНӨД ТҮНШ ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЦЭНДСҮРЭН

ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН МЕНЕЖЕР М.БУМЦЭНД

2025 он

# ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-2025 ОН

## АГУУЛГА


**1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .............................Error! Bookmark not defined.**

1.1 Төслийн товч мэдээлэл....................................................**Error! Bookmark not defined.**

**2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**........................................................................................................ 3

2.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах.................................................... 3

2.2 Усан орчин усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ...................................... 12

2.3 Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах.............15

**3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........................................................... 18

**4.** ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН **ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** 19

**5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ............................................................................................ 20

**6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**................................. 20

**7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**.......... 28

**8. ДҮГНЭЛТ**.................................................................................................................. 30

# ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-2025 ОН

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| **1.1. Төслийн нэр:** | “Гаалийн хяналтын бүс байгуулах” төсөл |
| **1.2. Төсөл хэрэгжүүлэгч:** | “Өнөд түнш” ХХК<br>• Улсын бүртгэлийн дугаар: 1111017297<br>• Регистрийн дугаар: 3655318<br>• Хаяг: Өмнөговь аймаг, Гурвантэс сум, 4-р баг, Урт, үйлчилгээ 2, 211 тоот<br>• Утас: 89018917, 96151696 |

### 1.3. Төслийн зорилго

Төслийн зорилго нь Гаалийн хяналтын бүсэд нүүрсийг тээврийн хэрэгслээр хүлээн авах, ачих, буулгах, хадгалах, жинлэх, контейнерт шингээх үйл ажиллагааг стандартад нийцүүлэн зохион байгуулах, тээвэр логистикийн үйл явцыг сайжруулахад чиглэнэ.

Төслийн нийт хамрах хүрээ 20 га талбайд хэрэгжих бөгөөд 183.3м*588м харьцаатай 10.8 га талбайд өдөрт дунджаар 40,000 тн ачаа буулгаж, ачих хүчин чадалтай байхаар төлөвлөж байна. Төслийн хэрэгжилтийн эхний шатанд өдөрт 33,400 тн орчим, сард 1,000,000 тн орчим нүүрс буулгаж, мөн тухайн хэмжээний нүүрсийг ачиж, Шивээхүрэн боомтоор нэвтрүүлнэ.

### 1.4. Төслийн үе шатны хэрэгжилтийн талаарх товч танилцуулга

“Өнөд Түнш” ХХК нь төслийн хүрээнд төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн бөгөөд одоогоор үйл ажиллагаа албан ёсоор эхлээгүй, хүлээлтийн горимд байна. 2025 оны байдлаар төслийн үндсэн үйл ажиллагаа бүрэн хүчин чадлаараа хараахан эхлээгүй бөгөөд бэлтгэл хангах, зохион байгуулалтын үе шатанд хүлээлтийн байдалтайгаар хэрэгжиж байна. Нийт 3 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

### 1.5. Төслийн талбайн байршил

“Гаалийн хяналтын бүс байгуулах” төсөл нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р баг буюу Бага-Овоо багийн нутаг Морин заг суурьшлын бүсэд хэрэгжинэ. Төслийн талбай нь Нарийн сухайтын бүлэг ордоос 30 орчим км зайд, Шивээхүрэн хилийн боомтоос 17.5 км зайд байрлана.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийн бууруулах төлөвлөгөөний хүрээнд агаар орчныг хамгаалах, газрын хэвлий хөрс ургамлан бүрхэвчийг хамгаалах, усны чанар нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр төлөвлөсөн ажлуудаа хийж гүйцэтгэсэн.

### 2.1 <u>АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ</u>

2.1.1 Салхины хурд 10 м/с-ээс дээш гарсан үед газар шорооны ажлыг түр хугацаанд зогсоож, агаарт тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Салхины хурдыг өдөр тутам хянаж, хяналтын үр дүнд үндэслэн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, зогсоох шийдвэрийг гаалийн хяналтын бүсийн менежер хариуцан гаргаж ажилласан болно.

2.1.2 Түлшний чанарын хяналт, техникийн үзлэг оношилгоонд тогтмол хамруулж агаар бохирдуулсны төлбөрийг улирал тутамд төлсөн. Гаалийн хяналтын бүсийн хэмжээнд ашиглах түлш, шатахуун болон машин механизмд шаардлагатай тос тосолгооны бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс гэрээний дагуу худалдан авалт хийх ба шинэ техник, ирэх бүрд техникийн хяналтын хуудсаар шалгаж шаардлага хангасан техникийг ажилд оруулах зөвшөөрөл олгож, засвар үйлчилгээ шаардлагатай техникт хугацаат үүрэг өгч ажилласан. Төслийн хэмжээнд ашиглагдах тоног төхөөрөмжийг эхний ээлжинд түрээслэж ашиглаж байна. Үүнд: Чингэлэг өргөгч-2, Сэрээт ачигч-1, Дугуйт ачигч-1, Хөнгөн тэрэг-1 ажилласан бөгөөд эдгээр тээврийн хэрэгслүүд нь жил бүр эрх бүхий байгууллагаас шалгадаг техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамрагдсан.


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical specifications

Улсын дугаар / Registration plate number: 7490БНХ
Марк, загвар / Make, model: LEXUS.LX470-J100
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж / Category, engine displacement: 4664, B, Евро IV
Бүх жин / Gross vehicle weight: 3110 кг, Ө.жин 2450 кг
Даац, суудлын тоо / Loading capacity, number of seats: 660 кг, 5
Төрөл / Type: Туулах чадвар сайтай
Зориулалт / Vehicle designation: Суудал
Арлын дугаар / Chassis number: JTJHT00W854000646
Бүхээгийн дугаар / Cabin number

MGL

Хөдөлгүүрийн дугаар / Engine number
Үйлдвэрлэсэн он / Year of manufacture: 2005
Импортолсон огноо / Date of importation: 2011-08-30
Өнгө / Color: Хар саарал
Тэнхлэгийн тоо / Axes
Улсын бүртгэлийн дугаарын өнгө / Color registration plate number
Өмчлөгч / Owner: Угтаабаяр МӨНХ-ЭРДЭНЭ
Хаяг / Address: Баянхонгор Баянхонгор 10 рашаант байдраг 1 128 7

ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
Certificate issuing authority

Бүртгэлийн ажилтан / Registration officer: У. Ган-өлзий
Тамга / Stamp
Гарын үсэг / Signature
2025 он 07 сар 28 өдөр
YYYY MM DD
Тусгай тэмдэглэл / Additional note

06341074

**Тээврийн хэрэгсэл**

| | |
|---|---|
| Улсын дугаар | 7490БНХ |
| Загвар | LEXUS LX470 |
| Үйлдвэрлэсэн он | 2005 |

**Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл**

| | |
|---|---|
| Үзлэгт орсон огноо | 2025/07/28 |
| Үзлэгт дахин орох огноо | 2026/07/28 |
| Тэнцсэн эсэх | Тэнцсэн |

# ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-2025 ОН

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical specifications

Улсын дугаар / Registration plate number: 2715УР
Марк, загвар / Make, model: HELI.CPCD85
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж / Category, engine displacement: , М, Бусад
Бүх жин / Gross vehicle weight: 12800 кг, Ө.жин 4300 кг
Даац, суудлын тоо / Loading capacity, number of seats: 8500 кг, 1
Төрөл / Type: Сэрээт ачигч
Зориулалт / Vehicle designation: Механизм
Арлын дугаар / Chassis number: L8611085XN33W5772
Бүхээгийн дугаар / Cabin number:

MGL

Хөдөлгүүрийн дугаар / Engine number:
Үйлдвэрлэсэн он / Year of manufacture: 2022
Импортолсон огноо / Date of importation: 2022-12-27
Өнгө / Color: Улбар шар
Тэнхлэгийн тоо / Axes:
Улсын бүртгэлийн дугаарын өнгө / Color registration plate number:
Өмчлөгч / Owner: ГОВЬХАНГАЙН ХӨДӨЛМӨР ХХК
Хаяг / Address: Өмнөговь Даланзадгад 05 Зүүнсайхан аргалант 1-14

№ 04324526

ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
Certificate issuing authority

Бүртгэлийн ажилтан / Registration officer: Б. Батсэ
Тамга / Stamp
Гарын үсэг / Signature
2023 Он 02 сар 01 өдөр
YYYY MM DD
Тусгай тэмдэглэл / Additional note

## Тээврийн хэрэгсэл

| | |
|---|---|
| Улсын дугаар | 2715УР |
| Загвар | Heli CPCD85 |
| Үйлдвэрлэсэн он | 2022 |

## Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

| | |
|---|---|
| Үзлэгт орсон огноо | 2025/06/17 |
| Үзлэгт дахин орох огноо | 2026/06/17 |
| Тэнцсэн эсэх | Тэнцсэн |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical specifications

Улсын дугаар / Registration plate number: 2665ММА
Марк, загвар / Make, model: Kalmar.DRU450
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж / Category, engine displacement: 9960, М, Евро III
Бүх жин / Gross vehicle weight: 45000 кг, Ө.жин 45000 кг
Даац, суудлын тоо / Loading capacity, number of seats: 0 кг, 1
Төрөл / Type: Авто ачигч
Зориулалт / Vehicle designation: Механизм
Арлын дугаар / Chassis number:
Бүхээгийн дугаар / Cabin number: H11600987

MGL

СОЛИВ

Хөдөлгүүрийн дугаар / Engine number:
Үйлдвэрлэсэн он / Year of manufacture: 2022
Импортолсон огноо / Date of importation: 2022-10-12
Өнгө / Color: Улаан
Тэнхлэгийн тоо / Axes:
Улсын бүртгэлийн дугаарын өнгө / Color registration plate number:
Өмчлөгч / Owner: ГОВЬХАНГАЙН ХӨДӨЛМӨР ХХК
Хаяг / Address: Өмнөговь Даланзадгад 05 Зүүнсайхан аргалант 1-14

№ 05994740

ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
Certificate issuing authority

Бүртгэлийн ажилтан / Registration officer: О. Уяш
Тамга / Stamp
Гарын үсэг / Signature
2025 Он 03 сар 12 өдөр
YYYY MM DD
Тусгай тэмдэглэл / Additional note

## Тээврийн хэрэгсэл

| | |
|---|---|
| Улсын дугаар | 2665ММА |
| Загвар | Kalmar DRU450 |
| Үйлдвэрлэсэн он | 2022 |

## Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

| | |
|---|---|
| Үзлэгт орсон огноо | 2024/07/25 |
| Үзлэгт дахин орох огноо | 2025/07/25 |
| Төлөв | Хугацаа дууссан |


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical specifications
СОЛИВ
MGL
ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
Certificate issuing authority

Улсын дугаар / Registration plate number: 2664MMA
Марк, загвар / Make, model: Kalmar DRU450
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж / Category, engine displacement: 9960, M, Евро III
Бүх жин / Gross vehicle weight: 45000 кг, О.жин 45000 кг
Даац, суудлын тоо / Loading capacity, number of seats: 0 кг, 1
Төрөл / Type: Авто ачигч
Зориулалт / Vehicle designation: Механизм
Арлын дугаар / Chassis number: H11600981
Бүхээгийн дугаар / Cabin number
Хөдөлгүүрийн дугаар / Engine number
Үйлдвэрлэсэн он / Year of manufacture: 2022
Импортлосон огноо / Date of importation: 2022-09-23
Өнгө / Color: Улаан
Тэнхлэгийн тоо / Axes
Улсын бүртгэлийн дугаарын өнгө / Color registration plate number
Өмчлөгч / Owner: ГОВЬХАНГАЙН ХӨДӨЛМӨР ХХК
Хаяг / Address: Өмнөговь Даланзадгад 05 Зүүнсайхан арлалт 1-14
№ 05994739
Бүртгэлийн ажилтан / Registration officer
Тамга / Stamp
Гарын үсэг / Signature
Он YYYY сар MM өдөр DD
Тусгай тэмдэглэл / Additional note

## Тээврийн хэрэгсэл

| | |
|---|---|
| Улсын дугаар | 2664MMA |
| Загвар | Kalmar DRU450 |
| Үйлдвэрлэсэн он | 2022 |

## Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

| | |
|---|---|
| Үзлэгт орсон огноо | 2024/07/25 |
| Үзлэгт дахин орох огноо | 2025/07/25 |
| Төлөв | Хугацаа дууссан |


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
Technical specifications
MGL
ГЭРЧИЛГЭЭ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА
Certificate issuing authority

Улсын дугаар / Registration plate number: 1267УР
Марк, загвар / Make, model: Shandong Lugong L956F
Ангилал, хөдөлгүүрийн багтаамж / Category, engine displacement: 9726, M
Бүх жин / Gross vehicle weight: 17450 кг, О.жин 12450 кг
Даац, суудлын тоо / Loading capacity, number of seats: 5000 кг.
Төрөл / Type: Авто ачигч
Зориулалт / Vehicle designation: Механизм
Арлын дугаар / Chassis number: VLGL956FTM0607801
Бүхээгийн дугаар / Cabin number
Хөдөлгүүрийн дугаар / Engine number
Үйлдвэрлэсэн он / Year of manufacture: 2021
Импортлосон огноо / Date of importation: 2021-07-06
Өнгө / Color: Шар
Тэнхлэгийн тоо / Axes
Улсын бүртгэлийн дугаарын өнгө / Color registration plate number
Өмчлөгч / Owner: ЦАГААН ХАД МӨНХИЙН ... ХХК
Хаяг / Address: Өмнөговь Цогтцэций ЦагаанБоо ... насосны ... ажилчдын хотхон 107
№ 03419364
Бүртгэлийн ажилтан / Registration officer
Тамга / Stamp
Гарын үсэг / Signature
2021 Он 08 сар 20 өдөр
YYYY MM DD
Тусгай тэмдэглэл / Additional note

## Тээврийн хэрэгсэл

| | |
|---|---|
| Улсын дугаар | 1267YP |
| Загвар | Shandong Lugong T938 |
| Үйлдвэрлэсэн он | 2024 |

## Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

| | |
|---|---|
| Үзлэгт орсон огноо | 2025/02/17 |
| Үзлэгт дахин орох огноо | 2026/01/01 |
| Тэнцсэн эсэх | Тэнцсэн |

Зураг №1. Техникийн үзлэг, оношилгоонд хамрагдсан баримт

| Гаалийн хяналтын бүсэд ажиллах машин механизмын бүртгэл | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| № | Компани | Төрөл | Парк дугаар | Ирсэн мото цаг /спидометр/ | Модель | Аралын дугаар | Улсын дугаар |
| 1 | Говь Хангай Хөдөлмөр ХХК | Чингэлэг өргөгч | KA003 | 2920 | Kalmar,DRU450 | H11600981 | 2664MMA |
| 2 | Говь Хангай Хөдөлмөр ХХК | Чингэлэг өргөгч | KA004 | 2889 | Kalmar,DRU450 | H11600987 | 2665MMA |
| 3 | Говь Хангай Хөдөлмөр ХХК | Сэрээт ачигч | SUU07 | 2486 | HELLCPCD85 | L8611085XN33W5772 | 2715УР |
| 4 | Цагаанхад Мөнхийн Их ХХК | Дугуйт ачигч | LO002 | 2659 | Shandong Lungong L956E | VLGL956FTM0607801 | 1267УР |
| 5 | Мөнх-эрдэнэ | Хөнгөн тэрэг | | 102471 | LEXUS.LX470-J100 | JTJHT00W854000646 | 7490БНХ |

Хүснэгт №1 Төслийн хэмжээнд ашиглаж буй техник тоног төхөөрөмжийн жагсаалт

| ТЕХНИКИЙН МЭДЭЭЛЭЛ | | | | | ХИЙГДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ | | | ХИЙГДЭХ ҮЙЛЧИЛГЭЭ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Өмнөх PM-д орсон | | | PM-д орох | | | |
| | | | | | | | | Үлдсэн | | | |
| Д/д | Техник, тоног төхөөрөмжийн нэр | Хувийн дугаар | Улсын дугаар | 11/13/2025 | Мото.цаг | Огноо | Төрөл | Мото.цаг | Хоног | Төрөл | Огноо |
| 1 | KALMAR,DRU450-62S5 | KA003 | 2504УР | 2920 | 2783 | 8/31/2024 | 2500 | 363 | 61 | 3000 PM | 2/15/2026 |
| 2 | KALMAR,DRU450-62S5 | KA004 | 2505УР | 2889 | 2542 | 7/20/2024 | 2500 | 153 | 26 | 3000 PM | 1/11/2026 |

| KALMAR DRU450-62S5 #KA003, KA004 | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| № | Сэлбэгийн нэр | Программ код | Сэлбэгийн дугаар | Хэмжих нэгж | Тоо ширхэг | ТҮ-ний үечлэл | | | |
| | | | | | | ТҮ1 | ТҮ2 | ТҮ3 | ТҮ4 |
| | | | | | | 500 | 1000 | 2000 | 4000 |
| 1 | Хөдөлгүүрийн тосны шүүр | TK101137 | 924548.0519 / J062710100 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 2 | Хөдөлгүүрийн тосны шүүр | TK100575 | 924548.0518 / J061900100 | ш | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| 3 | Агаар шүүгч, гадна | TK101135 | 923855.1225 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 4 | Агаар шүүгч, дотор | TK101136 | 923855.1224 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 5 | Түлшний шүүр /WS | TK100674 | J018289 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 6 | Түлшний шүүр | TK100008 | J018288 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 7 | Түлшний шүүр /Filter insert | TK101057 | J028833 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 8 | Кропны шүүр | TK110994 | 923944.3095 | ш | 2 | - | 2 | 2 | 2 |
| 9 | Brake high pressure filter | TK100016 | 923976.2805 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 10 | Breathing dilter brake oil tank | TK100012 | 923855.1185 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 11 | Hyd filter servo oil | TK100015 | 923944.2530 | ш | 1 | - | 1 | 1 | 1 |
| 12 | Hyd oil fine filter | TK100124 | 922316.0007 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 13 | Hydraulic oil return filter | TK110996 | 922315.0004 | ш | 2 | - | 2 | 2 | 2 |
| 14 | Hyd breather oil tank filter | TK100011 | 923855.1183 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 15 | Cab filter | TK102593 | 924530.01.77 | ш | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 16 | Хөдөлгүүрийн тос | TK800019 | VOLVO 10w30 | л | 37 | 37 | 37 | 37 | 37 |
| 16 | Хөдөлгүүрийн тос | TK800018 | VOLVO 15w40 | л | 37 | 37 | 37 | 37 | 37 |
| 17 | transmission oil | TK800017 | ATF Dexron III | л | 75 | - | 75 | 75 | 75 |
| 18 | Диффранциал | TK800008 | API GL5/85w90/80w140 | л | 72/50 | - | - | 72 | 72 |
| 19 | Захын дамжуулагч | TK800008 | API GL5/85w90/80w140 | л | 12*2 | - | - | 24 | 24 |
| 20 | Тормос | TK800021 | SAE 5w30 /CAT TO-4 | л | 140 | - | - | 140 | 140 |
| 21 | Load handling / rotating motor | TK800008 | API GL5/85w90/80w140 | л | 3.7 | - | - | 3.7 | 3.7 |
| 22 | Refrigerant / Фреон | GK530111 | R134a530111 | л | 0.2 | - | - | 0.2 | 0.2 |
| 23 | Coolant | TK800020 | Volvo | л | 45 | - | - | - | 45 |
| 24 | Гидрийн шингэн | TK800016 | ISO VG32/VG68 | л | 600 | - | - | - | 600 |
| 25 | Товуд / Өвөл цэгэн тосолгоо | TK800024 | NLGI 0 | кг | 4 | 4 | 4 | 4 | 4 |
| | Товуд / Зун цэгэн тосолгоо | TK800025 | NLGI 2 | кг | 4 | 4 | 4 | 4 | 4 |
| | Товуд / Гулгаа өвөл зун тогтмол | TK800001 | NLGI 3 | кг | 5 | 5 | 5 | 5 | 5 |
| 26 | Шил арчигчийн шингэн | TK500081 | -35 | л | 5 | 5 | 5 | 5 | 5 |

Хүснэгт №2 Төслийн хэмжээнд ашиглаж буй техник тоног төхөөрөмжийн үзлэг, урсгал засвар үйлчилгээний төлөвлөгөө болон биелэлт







Зураг №2. Гаалийн хяналтын бүсэд теник, тоног төхөөрөмж шинээр ашиглалтад оруулах үзлэгийн маягт

**Дугуйт ачигч LO002 хийгдсэн засвар үйлчилгээ**

Тус техникт250 мот цагийн үйлчилгээ хийсэн. Үүнд:

- -Хөдөлгүүрийн тос-10W30 CI4 20л
- -Хөдлгүүрийн тосны шүүр-2ш
- -Хөдөлгүүрийн агаар шүүгч- дотор гадна 1ш
- -Түлшний тунгаагуурт шүүр-1ш
- -Түлшний шугаман шүүр-1ш
- -Түлшний дамжуулах шүүр-1ш
- -Цэгэн тосолгоо

Мөн техникийн хяналтын үзлэгийн дагуу хөдөлгүүр,жолоодлого болон тоормосны систем,гидро болон хүч дамжуулах анги,цахилгаан системд үзлэг хийж хариуцсан операторт хүлээлгэн өгсөн.

| | Нэр | Гарын үсэг |
|---|---|---|
| Танилцуулсан: | | |
| Цахилгаанчин | А. Дашням | /......................./ |
| Механик | А. Хулан | /......................./ |
| Танилцсан | | /......................./ |

**Сэрээт өргөгчийг хүйтэнд асаах үеийн зааварчилгаа**

Асаахаас өмнө

- -Хөдөлгүүрийн тосны түвшинг шалгах
- -Өвлийн зориулалтын дизель түлш ашиглах
- -Аккумуляторыг дулаан газар хадгалсан цэнэг дүүрэн байх
- -Халаагч пүүжин ашиглаж хөдөлгүүрийг гэсгээх
- -Гар халаагчыг хэт удаан буюу 10-с дээш секунт ажиллуулж болохгүй
- -Стартерийг хэт удаан буюу 10секунтээс дээш хугацаанд дарахгүй байх
- -Түргэн асаагч эфир ашиглах үед хэт их цацахгүй байх

Асаасны дараа

- -Хөдөлгүүрийг асаамагц огцом хаазлахгүй 5-10минут нормальдаж тосны даралт,темпартур хэвийн болохыг хүлээнэ
- -Гидрийн шингэн царцуу байгаа тул эхний 5-10минут огцом өргөх үйлдэл хийхгүй байх

Анхаарвал зохих зүйл

- -Техникийг дулаан газар байрлуулж байх
- -Урьдчилан халаах систем суурилуулах(Халуун тогоо 24v)
- -Хөдөлгүүрийг ил гал түлж халаахыг хориглоно.

| | Нэр | Гарын үсэг |
|---|---|---|
| Танилцуулсан: | | |
| Цахилгаанчин | А. Дашням | /......................./ |
| Механик | А. Хулан | /......................./ |
| Танилцсан | Э. Анхбаатар | /.......Анхбаатар........./ |

MNAS Accreditation system
TL 042
MNS ISO/IEC 17025

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨВ ЛАБОРАТОРИ
Монгол улс, Улаанбаатар хот СХД 20-р хороо
Петровис Трейдинг ХХК-ийн агуулах
Утас : 976 7575 0505

NIC since 1941

**СОРИЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН № 2896/25**
**/ Analysis report №/**

ПО-М-274-01

| ДЭЭЖИЙН МЭДЭЭЛЭЛ /Sample data/ | |
|---|---|
| Дээж ирүүлсэн байгууллагын нэр /Organization of the request for analysis/ | Толгойт Агуулах |
| Газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл /Sample type/ | Дизель түлш К5 - 2 |
| Дээж авсан объект /Object of sampling/ | 12-р сав |
| Дээж авсан ажилтан / албан тушаал нэр /Sampled by/ | Химич Д.Дэнсмаа |
| Дээжийн хэмжээ, литр /Sample capacity/ | 1.0 |
| Дээжийн лацны дугаар / Seals №/ | байхгүй |
| Дээж авсан огноо / Date of sampling/ | 2025.10.24 |
| Шинжилгээ хийгдсэн огноо / Date of analysis/ | 2025.10.24 |
| Шинжилгээний тайлан олгосон огноо / Date of analysis report / | 2025-10-28 |

**СОРИЛТЫН ҮР ДҮН**

| № | Үзүүлэлт /Property/ | | Хэмжих нэгж /Units/ | Аргачлал /Methods/ | Норм /Specification parameters/ | Үр дүн /Results/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цетан тоо* /Cetane number/ | | - | Багажны аргаар / by the instruction of the apparatus/ | 49 багагүй /min 49/ | 51 |
| | Цетан индекс /Cetane index/ | | - | MNS:GOST 27768 | 46 багагүй /min 46/ | 52 |
| 2 | 20°C дахь хувийн жин /Density at 20°C/ | | гр/см³ /gr/cm³/ | MNS GOST R51069 | 840 ихгүй /max 840/ | 0.8206 |
| 3 | Найрлагын бүрэлдэхүүн /Distillation/ | 180°C –д нэрэгдэх ээлхүүн / Vol recovered at 180°C / | % | MNS ISO 3405 | 10 ихгүй / max 10/ | 1 |
| | | 360°C –д нэрэгдэх ээлхүүн / Vol recovered at 360°C / | | | 95 багагүй / min 95/ | 98 |
| | | 95% нэрэгдэх хэм /95% vol recovered/ | | | 360 ихгүй /max 360/ | 317 |
| 4 | Шүүгдэх чанарын дээд температур /Cold filter plugging point/ | | ° C | MNS 5800 | -26 ихгүй /max -26/ | -37 |
| 5 | Булингартах хэм /Cloud point/ | | ° C | MNS ASTM D2386 | -16 ихгүй /max -16/ | -36 |
| 6 | Битүү тигельд дөл үүсэх хэм /Flash point in closed cup/ | | ° C | MNS 0333 ISO2719 | 55 багагүй /min 55/ | 58 |
| 7 | 40°C –д Кинематик зууралдлага /Kinematic Viscosity at 40° C/ | | мм²/с | MNS ASTM D445 MNS 0480 | 1.5-4.0 /max 4.0/ | 2.8 |
| 8 | Хүхрийн хэмжээ /Sulfur content/ | | мг/кг /mg/kg/ | ASTM D 2622-05 БС:Н-С-/03/170-1 | 10 ихгүй / max 10/ | 6 |
| 9 | Зэс хавтгайн туршилт 50°C / Copper Strip test at 50°C/ | | 3 цаг /3 hour/ | MNS ISO 2160 | Ангилал 1 /class 1/ | 1 |
| 10 | Усны агууламж /Water content/ | | мг/кг /mg/kg/ | MNS ASTM D1744 | 200 ихгүй /max 200/ | байхгүй |
| 11 | Өнгө /Colour/ | | | MNS ISO 2049 | -- | 0.2 |
| 12 | Механик хольцын хэмжээ / Mechanical impurities/ | | % | MNS 3697 | Байхгүй /nil/ | байхгүй |

Тайлбар: * - Итгэмжлэлийн хүрээнд ороогүй үзүүлэлт

Шинжилгээ хийсэн: Химич / Д.Дэнсмаа /
/Tested by/

Баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч З.Пүрэвсүрэн
/Certified/

Зураг № 3. Түлшний чанарын шинжилгээний дүн

2.1.3 Тоосжилтыг бууруулах зорилгоор Гаалийн хяналтын бүсийг тойруулан 7 метрийн өндөртэй салхинаас хамгаалалтын торон хашааг барьж байгуулсан. Тус хашаа нь салхины давамгай чиглэл болох баруун хойд болон баруун талын дагуу нийт 756 ширхэг хавтастайгаар суурилуулагдсан. Ашиглалтын явцад эвдрэл гэмтэл илэрсэн тохиолдолд гүйцэтгэгч талаас тухай бүр засвар үйлчилгээ хийж, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

БАТЛАВ.
"ӨНӨД ТҮНШ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.ОНОН

БАТЛАВ.
"ТИТАНТАУЭР КОНСТРАКШН" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ЧУЛУУНБАТ

**БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ /ХАШАА/ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас захиалагч "Өнөд Түнш" ХХК РД:3655318 /цаашид "Захиалагч" гэх/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал П.Онон, нөгөө талаас "Титантауэр Констракшн "ХХК" РД:5306329 /цаашид "Ажил гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлж Ерөнхий инженер Б.Баасандаш хамтад нь /цаашид "Талууд" гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг болон бусад холбогдох хуулийн заалтуудыг тус тус удирдлага, үндэслэл болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалга, ажлын даалгавар, батлагдсан зургийн дагуу Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5 дугаар баг, Бага Овоо хаягт өгсөн координат, төлөвлөлтийн зургийн дагуу хавсралт 1-т заасан шаардлагад нийцсэн хашаа угсрах ажил /цаашид "Гэрээт ажил, Үр дүн" гэх/-ыг гэрээнд заасан нөхцөлийн дагуу, өөрсдийн зардал, материалаар чанар, стандартын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон ажлын гүйцэтгэлийн төлбөрийг Ажил гүйцэтгэгч талд бүрэн төлөхөөр харилцан тохиролцов.

1.2 Энэхүү гэрээний зорилго нь хэлцэл буюу гэрээний нөхцөл, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

**Хоёр. Ерөнхий нөхцөл**

2.1 Талууд нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хуулийн болон Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудыг удирдлага болгон, мөрдөж ажиллахаас гадна норм, нормативын шаардлагын дагуу чанартай хийж гүйцэтгэх, гэрээний дагуу хамтран ажиллах хугацаанд Талуудын харилцан бизнесийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандаж, гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, үнэнч шударгаар биелүүлэх, харилцан ашигтай, идэвх санаачилгатай байх зарчмуудыг баримтлан ажиллана.

2.2 Талууд нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхийн тулд доорх чиг үүргийг гүйцэтгэн, хариуцлага хүлээн ажиллана. Үүнд:

**Захиалагч тал:**

2.2.1 Захиалагч нь Ажил гүйцэтгэгчид хийж гүйцэтгэх ажлын талаар шаардлагатай мэдээлэл, мөн ажлын гүйцэтгэлийн боломжтой нөхцөлөөр хангах, ажлын гүйцэтгэлийн талаар санал өгөх, дахин засварлах, өөрчлөх шаардлага тавих, зөвхөн Ажил гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх, ажлын хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэрийн дагуу хугацаанд нь төлөх, үр дүнг хүлээн авах чиг үүргийг гүйцэтгэнэ.

1

ЗАХИАЛАГЧ:
"ӨНӨД ТҮНШ" ХХК -г төлөөлж
Гүйцэтгэх захирал
П.Онон
/гарын үсэг/
Хаяг: Өмнөговь, Гурвантэс, 4-р баг, Урт, үйлчилгээ 2, 211 тоот
Утас: 99000704

ГҮЙЦЭТГЭГЧ:
"ТИТАН ТАУЭР КОНСТРАКШН" ХХК -г төлөөлж Гүйцэтгэх захирал
Б.Баасандаш
/гарын үсэг/
Хаяг: БГД, 5-р хороо, 10-р хороолол, АОС, 99-2 тоот.
Утас: 976-99111069, 976-99075035

**Ажлын даалгавар**

**6.3м өндөртэй 756м урттай хашаа, 6.3м өндөртэй 3ш хаалга ажлын даалгавар**

1. Тулгуур, баганууд нь цайрдсан төмрөөр хийгдсэн
2. 30 метр/сек хүртэлх хурдтай салхинд унахгүй тэсвэртэй, хэвийн нөхцөл гэж үзнэ.
3. Хашааны хавтасны урт 7 метр, өргөн 90 см хэмжээтэй, хар хөх, цэнхэр энгийн
4. 2 үе буюу 1.8 метр хашаа нэмж өндөрлөх боломжтой байх
5. Тулгуур багана дээр камер, гэрэл суулгаж болохуйц даацтай, боломжтой
6. Хашаан доогуур зайгүй байх
7. Гарцын хаалга болон хаалганы доогуур зайгүй байх
8. Ажлын зургийн дагуу

Зураг №4. Барилгын угсралтын ажил / 7 метрийн өндөртэй хашаа / гүйцэтгэх гэрээ



Зураг №5. 7 метрийн өндөртэй хашаа барьж байгуулсан.

**“Барилга угсралтын ажил /хашаа/ засварласан ажлын акт**

Захиалагч: “Өнөд түнш” ХХК

Байршил: Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Морин заг суурьшлын бүс гаалийн хяналтын бүс

“Титан Тауэр Констракшн” ХХК хүлээлгэж өгсөн хашаа хүчтэй салхины улмаас эвдрэл үүссэнийг гэрээт ажлын баталгаат хугацааны хүрээнд засварлав.

**Ажил хүлээлгэн өгсөн**: “Титан Тауэр Констракшн” ХХК

Засварчин:................/................/

Засварчин:................/................/

**Ажил хүлээн авсан:** “Өнөд Түнш” ХХК

Гаалийн хяналтын бүсийн менежер:................/................/



Зураг №6. 7 метрийн өндөртэй хашаанд эвдрэл гэмтэл үүссэн үед тухай бүр засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэж байна.

2.1.4 Машин техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор талбайд тогтмол усалгаа, арчилгааг тогтмол хийж байна. Усны машинаар талбайг усалсны дараа замын нягтруулалтыг сайжруулах үүднээс индүү ашиглан индүүдэж, тоосжилт нэмэгдэхээс урьдчилан сэргийлж байна.








Зураг №7. Талбайн усалгаа арчилгаа индүүдлэг хийж буй зураг



Зураг №8. Төслийн талбайд машин зогсоох зогсоолын талбай. Зогсоолын талбай мөн хөдөлгүүрээ унтраана уу гэсэн гэсэн тэмдэг тэмдэглэгээ байршуулсан

## 3. УСАН ОРЧИН ( ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ ) УСАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Үйл ажиллагаа хэвийн явагдаж, ГХБ-н ажилчдын ундны усны хэрэгцээг хангах гүний худаг шинээр гаруулсны дараа эрүүл ахуйн бүс тогтоолгох хүсэлт хүргүүлнэ. Одоогоор ундны усны хэрэглээг Гурвантэс сумын Моринзаг суурьшлын бүсийн гүний худаг эзэмшигчтэй гэрээ байгуулж усны машинаар тээвэрлэн авч байна.

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| 5205146234<br>MN19001500520514623 4 | MN080005005589020746 | 180,000.00 MNT | Амжилттай |
| Шилжүүлэгчийн нэр<br>БУМЦЭНД МӨНХДОРЖ | Хүлээн авагчийн нэр<br>ГЭНДЭНДОРЖ ОНДООХОРОЛ | Гүйлгээний утга<br>ӨНӨД ТҮНШ УС,ГЭНДЭНДОРЖ ОНДООХОРОЛ,ХААН | |
| | Хүлээн авагчийн банк<br>ХААН ТӨВ БАНК | Гүйлгээний огноо<br>2025-11-14 | |

01 ГОЛОМТ БАНК ХУУЛБАР ҮНЭН

Зураг №9. Ус авсан төлбөрийн гүйлгээний баримт



БАТЛАВ:
"ӨНӨД ТҮНШ" ХХК
Б.ЦЭНДСҮРЭН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ГҮНИЙН ХУДГААС УС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

№: 03/25

*Энэхүү бичиг баримт нь байгууллага, хувь хүний нууцаар хамгаалагдсан бичиг баримт болно.*

Огноо: 2025.01.27



УСНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Байгаль орчны Сайдын 2004 оны 185 тоот тушаалаар батлав

ӨРӨМДМӨЛ ХУДГИЙН ТЕХНИКИЙН ПАСПОРТ

ЭНЭХҮҮ ПАСПОРТЫГ ХУДАГ ЭЗЭМШИГЧ ӨМЧИЛНӨ



Сум, дүүрэг, хороо Гурвантэс
Эзэмшигч иргэн, байгууллагын нэр
Өрөмдмөл худгийн

Улсын № 1504107001
Байршил буй газрын нэр, хаяг

Ус ашиглах гэрээний №

Ус ашиглах эрхийн бичгийн №

Худаг гаргасан (аж ахуйн нэгж) Их эртөнц ХХК
Захирал

20 он сар өдөр

Баталгаажуулсан.

Өмнөговь аймаг (нийслэл)-ийн Байгаль орчны албаны тамга

Дарга
20 он сар өдөр

4



Худгийн байршлын солбилцол

Уртраг: 42°46'30"
Өргөрөг: 101°14'56.3"
Үнэмлэхүй өндөр: м,

| Аймгийн код | Сумын код | Худгийн зориулалтын код |
|---|---|---|
| 46000 | 004 | 1504107001 |

Өмнөговь аймгийн, хотын Гурвантэс сумын дүүргийн, хорооны, багийн газарт, -д зориулан Өмнөговь аймгийн, (хотын) Их эртөнц компанийн менежер ахлагчтай анги, бригад XY-2B маркийн станокоор аргаар

Уул худгийн хронологийг 2010 он 6 сарын 20 өдрөөс 2010 он 6 сарын 30 өдөр хүртэл өрөмдөж гаргав.

5

Зураг №10. Гүний худгаас ус худалдах, худалдан авах гэрээ

3.2 Ундны усны хангалт ба ажилчдын эрүүл мэндийн дэмжлэг: Гаалийн хяналтын бүсийн ажиллах орчныг эрүүл, аюулгүй байлгах зорилгоор нийт ажилчдад өдөр бүр ундны усыг тогтмол олгодог. Ажилтны тоо болон усны хэрэглээний нормд үндэслэн нэг ажилтан бүрт 2 литр ундны ус хуваарилан олгож, ажлын хугацаанд хангалттай ус уух нөхцөлийг бүрдүүлсэн. Усны хангалт нь дараах давуу талтай. Үүнд:

- ✓ Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, шингэний дутагдлаас сэргийлэх
- ✓ Ажлын бүтээмж, анхаарал төвлөрлийг сайжруулах
- ✓ Халуун, хуурай нөхцөлд ажиллаж буй ажилчдад шаардлагатай шингэн нөхөх боломж бүрдүүлэх
- ✓ Ундны усны чанарын шаардлагыг хангасан эх үүсвэрээр тогтмол хангах
- ✓ Энэхүү тогтолцоо нь ажилчдын тав тух, эрүүл мэндийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах менежментийн чухал хэсэг болж байна.


НХМаягт БМ-6

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

[illegible]
(Байгууллагын нэр)

ШААРДАХ ХУУДАС № .....

20 25 он 11 сар 01-15 өдөр

Хэнээс: [illegible]
(овог, нэр, албан тушаал)

Хаана: [illegible]
(цех, тасаг, хэлтсийн нэр)

Зориулалт:

| № | Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар | Код | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүссэн | Зөвшөөрсөн | Олгосон |
| 1. | [illegible] 0,5. | | ш | 25. | 25 | 25 |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | Дүн | | | | | 25 |

Зөвшөөрсөн:
Дарга ................/................/
Нягтлан бодогч ................/................/

Олгосон нярав ................/................/
Хүлээн авсан ................/ [illegible] /
Шаардах хуудас бичсэн ................/................/




Зураг №11 Усны бүртгэл

3.3 Усны нөөцийг зүй зохистой, үр ашигтай ашиглах талаар ажилтнуудад ойлголт өгөх, ухуулга сурталчилгаа явуулах зорилгоор мэдээллийн самбар, санамж хуудсуудыг тосгуур болон усны цоргын орчимд байршуулсан.





## 4. ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

4.1 Зөөврийн шатахуун түгээгүүрээс түлш олгох хэсэгт шатахууны асгарч хөрс бохирдохоос урьдчилан сэргийлж геомембран хамгаалалтын материал дэвсэж, асгаралтын иж бүрдэл байрлуулсан. Мөн хоосон сав, бортого онгойлгогчийг бэлэн байдалд байлгаж байна.






Зураг №12. Ашиглаж дууссан тосны сав ялгах хэсэг болон хэрэгцээгүй тос юүлэх сав






Зураг №13. Түр ШТС-д асгаралтын иж бүрдэл байрлуулсан байдал

4.2 Гаалийн хяналтын бүсийн ажилтан, үйлчлүүлэгчдэд зориулан 40 тонн багтаамжтай контейнерийг иж бүрэн тохижуулж, холбогдох стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн боловсон нойлын байгууламжийг байгуулсан. Тус байгууламж нь ажиллах болон ашиглахад тав тухтай, аюулгүй орчныг бүрдүүлсэн бөгөөд байнгын ашиглалтад оруулах нөхцөл бүрдсэн. Бохир усны хуримтлал, цуглуулалтыг зохистойгоор шийдвэрлэх зорилгоор газар доор 25 тонн багтаамжтай бохир усны ёмкос суурилуулсан. Ёмкосын ашиглалт, бохир усны

түвшний хяналт, тээвэрлэлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх зорилгоор “Батаарын Өлгий” ХХК-тай гэрээ байгуулан, бохир усыг тогтмол давтамжтайгаар соруулж, Гурвантэс сумын төвлөрсөн бохир усны хаягдлын цэгт аюулгүй, стандартын дагуу тээвэрлэн зайлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.






Зураг №14. Бохир соруулах үйл явц болон бохирын ёмкость суурьлуулсан





Зураг №15. Ажилчдын тав тухтай орчинд ажиллах амьдрах нөхцөл бүрдүүлж нойл, халуун усны асуудал шийдсэн.

4.3 Тогтоосон маршрутаар зорчих, тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан. Нүүрс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний болон хүнд машин механизмын нөлөөгөөр тоосжилт үүсэх бөгөөд, гаалийн хяналтын бүсийн орчимд агаар дахь тоосжилт нэмэгдэхээс сэргийлэн гаалийн хяналтын бүсийн гадна болон дотор тал, зам талбайг нягтаршуулж, дагдаршуулсан мөн нийт талбайг хашаалж тусгаарлаж шаардлагагүй зам гарцуудыг хааж, замын хөдөлгөөний чиглүүлэх болон мэдээлэх тэмдэг хурд, хязгаарлах тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын самбар 88 ширхгийг байрлуулж, 20га талбайг нягтаршуулж, мөн 7 метр болон 2 метр өндөртэй хашаагаар тусгаарласан.


















"Өнөд Түнш" ХХК ГХБ-д байрлуулсан замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ

| Д/Д | Тэмдэг нэр | Ширхэг | Зураг |
|---|---|---|---|
| 1 | Зогс | 11 |   |
| 2 | Парк | 4 |   |
| 3 | Цуглarax цэг | 2 |   |
| 4 | 5 км | 7 |   |
| 5 | 10 км | 4 |   |
| 6 | 20 км | 2 |   |
| 7 | Эргэлтийн тэмдэг | 4 |  |
| 8 | ШТС тэмдэг | 1 |  |
| 9 | Эгнээний тэмдэг | 10 |   |
| 10 | Чиглэлийн тэмдэг | 2 |  |
| 11 | Хөдөлгүүрээ унтраана уу | 5 |  |

Зураг №16. Замын хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээ

## 5. <u>БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</u>

Тус бүлгийн хүрээнд биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх ажлын үр дүн 2025 оны байдлаар бүртгэгдээгүй бөгөөд ирээдүйд шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой. Ногоон байгууламжийн төлөвлөгөө болон хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тусад нь тусгаж өгсөн болно.

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

6.1 Төслийн талбайн орчны өнгө үзэмжийг сайжруулах, байгалийн зохицолд нийцсэн орчныг бүрдүүлэх зорилгоор намрын тариалалтаар 400 ширхэг хайлаасны суулгацыг 2 эгнээгээр тарьсан. Ургамал хооронд 2 метр, эгнээ хооронд 1 метрийн зайтайгаар суулгаж, суулгацын эрүүл мэнд, өсөлтөд анхааран ажиглалт, арчилгаа хийж байна.



Зураг №17. Мод тарих ажлын явц

**Шилжүүлгийн мэдээлэл**/Transaction information
Журналын /Journal No: **30315046**
Гүйлгээний дугаар /Poid: **1325202157**

Системийн огноо/System Date: **2025-10-28 16:35:48**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дт | IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number<br>5170019511 | Нэр/Name | Дүн/Amount<br>1,520,000.00 MNT | Ханш/Rate<br>1.00 |
| Кт | Банкны дугаар/Branch No<br>GLMTMNUB<br>IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number<br>MN130015 005205154587 | Банкны нэр/Bank Name<br>ГОЛОМТ БАНК<br>Нэр/Name<br>ГОВИЙН ТООРОЙН ТӨГӨЛ ХХК | 1,520,000.00 MNT | 1.00 |

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-СРМ 2862468 400Ш ХАЙЛААСНЫ СУУЛГАЦ

Зураг №18. Хайлаасны суулгац худалдаж авсан баримт

## 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

7.1 Одоогоор төсөл хэрэгжиж буй талбай орчимд соёлын өв олдоогүй ба олдсон тохиолдолд соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор Гурвантэс сумын бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэн ажиллах болно.

## 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

8.1 Цахилгааны газардуулга ба аюулгүй ажиллагааны хэмжилт: Гаалийн хяналтын бүсийн цахилгааны найдвартай ажиллагааг хангах, ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой цэгүүдэд газардуулгын системийг угсралт хийж, ОМ-ын хэмжилтийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн. Үүний үр дүнд цахилгааны системийн аюулгүй ажиллагаа сайжирч, ажиллагсад, тоног төхөөрөмжийг цахилгаан шууд болон богино залгааны эрсдлээс хамгаалах боломж бүрдсэн. Үүнд:

- ✓ 1500 кВА хүчин чадалтай КТПН дэд өртөө
- ✓ Нэмэлт цахилгаан үүсгүүр генератор
- ✓ Цахилгааны самбарууд (нийт 9 цэг)

Эдгээр цэгүүдэд газардуулгын электрод, хуваарилах дамжуулагч, хамгаалалтын холбоосуудыг стандартын дагуу суурилуулж, ашиглалтанд орохоос өмнө газардуулгын эсэргүүцлийн ОМ хэмжилтийг хийж, үзүүлэлтүүдийг нормын шаардлагад нийцэж буйг баталгаажуулсан.




Зураг №19. Газардуулга ОМ хэмжилт

8.2 Үерийн ус зайлуулах байгууламж: Гаалийн хяналтын бүс рүү орж гардаг нүүрс тээврийн замын хамгаалалт, замын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үерийн ус зайлуулах ган хоолойн байгууламжийг шинээр хийж суурилуулсан. Үүнд:

- ✓ Нийт 49 метр урттай ган хоолой
- ✓ 2 цэгт төлөвлөн байршуулсан

Эдгээр ус зайлуулах байгууламж нь бороо, үерийн үеийн гадаргын усыг саадгүй нэвтрүүлэх, замын эвдрэл, шуурга, усанд автах эрсдэлийг бууруулах үүрэгтэй. Үр дүн нь:

- ✓ Замын бүтээцийн эдэлгээ уртассан
- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саатах эрсдэл багассан
- ✓ Үерийн ус зам руу орох, замын суурь сулрах асуудал багассан
- ✓ Аюулгүй, тасралтгүй нүүрс тээвэрлэлтийн нөхцөлийг бүрдүүлсэн

Энэхүү шийдэл нь байгаль цаг уурын эрсдэлтэй бүсэд замын найдвартай ашиглалтыг хангах чухал дэд бүтцийн ажил болсон.






Зураг №20. Үерийн ус зайлуулах байгууламж

8.3 Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор оффис болон төслийн талбайн эрсдэл өндөртэй, хүн ихээр зорчдог тодорхой цэгүүдэд галын сараа, гал унтраах хорнуудыг холбогдох стандарт, норм дүрмийн шаардлагад нийцүүлэн байршуулсан. Тус гал унтраах хэрэгслүүдийг харагдахуйц, саадгүй ашиглах боломжтой байршилд суурилуулж, гал гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн галын аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээг байршуулж, гал унтраах хэрэгслийн байршлыг ажилтнуудад таниулсан. Гал унтраах хор, сараануудын хэвийн ажиллагаанд тогтмол үзлэг хийж, хугацаа дууссан болон эвдрэл гэмтэлтэй хэрэгслийг тухай бүр шинэчлэн сольж, галын аюулгүй байдлыг тогтвортой хангаж ажиллаж байна.







8.4 Хоолны газрын эрүүл ахуйг сахиулах, ажилчдын хувийн эрүүл ахуйг сахих дадал зуршлыг хэвшүүлэх талаар мэдээлэл сургалтыг сар бүр тогтмол зохион байгуулж байна. Төслийн талбайд ажиллаж буй бүх ажилтанд халдварт өвчин, эрүүл ахуйн талаарх ойлголт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний мэдээллийг хүргэх зорилгоор сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Сургалтын үеэр халдварын эрсдэл, хувийн хамгаалах хэрэгслийн зөв хэрэглээ, ариутгал, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тайлбарлаж, ажилтны ойлголт баталгаажсаны дараа бүртгэлжүүлдэг.







Зураг №21. Сургалтын үйл явцын зураг

8.5 Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор байгууллагын хэмжээнд анхны тусламжийн хүртээмжийг сайжруулсан. Энэхүү ажлын хүрээнд нийт 7 оффисын өрөөнд стандарт шаардлагад нийцсэн анхны тусламжийн хайрцаг байршуулсан бөгөөд хайрцаг бүрийг өдөр тутмын үзлэг, дүүргэлтээр хангаж, шаардлагатай үед ажилчид шуурхай ашиглах нөхцлийг бүрдүүлсэн. Мөн анхны тусламжийн хайрцагийн жагсаалт, байршлын зураглалыг шинэчилж, ажилчдад мэдээлэл хүргүүлсэн.






Зураг №22. Анхны тусламжын хайрцаг

8.6 Аюулгүй ажиллагааны сургалт, хяналт: Төслийн үйл ажиллагаанд оролцож буй бүх ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах зорилгоор өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол зохион байгуулдаг. Зааварчилгааны үеэр тухайн өдрийн ажилбар, боломжтой эрсдэлүүд, урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон хамгаалах хэрэгслийн зөв хэрэглээний талаар мэдээлэл өгч, ажилчдын ойлголт, мэдлэгийг баталгаажуулсны дараа гарын үсэг зуруулж бүртгэлжүүлдэг. Энэхүү арга хэмжээ нь осол, эндэгдлээс сэргийлэх, ажилтнуудын аюулгүй байдлын мэдлэг, хариуцлагыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой бөгөөд бүртгэлүүдийг тогтмол хадгалж, тайлан, мониторингийн мэдээнд ашиглаж байна.





Зураг №23. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Таниулах самбаруудын ашиглалт: Аюулгүй ажиллагаа болон байгаль орчны хамгаалалтын талаарх мэдээллийг ажилтнуудад ойлгомжтой, хүртээмжтэй хүргэх зорилгоор нийт оффис, ажлын байр бүрт таниулах самбарууд байршуулсан. Эдгээр самбаруудад:

- ✓ Аюулгүй ажиллагааны заавар, дүрэм
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх эрсдэлийн жагсаалт
- ✓ Галын аюулгүй байдлын заавар
- ✓ Яаралтай үед авах арга хэмжээ
- ✓ Ослын үед холбоо барих дугаарууд
- ✓ Хог хаягдлын ангилалт, хяналтын мэдээлэл зэрэг чухал мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж, ажилтан бүр өдөр тутамд мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлсэн. Энэ нь ажилчдын мэдлэг, хариуцлагыг дээшлүүлэхээс гадна байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулахад үр дүнтэй арга хэмжээ болж байна.


















Зураг №24. Таниулах самбарууд

8.7 Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах: Манай байгууллага нь ажилчдынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, тав тухтай нөхцөлийг хангах зорилгоор өвөл, зун гэсэн хоёр улирлын ажлын хувцсыг тогтмол олгодог.

- ✓ Зуны ажлын хувцас – халуун улиралд тохиромжтой, хөнгөн, агаар нэвтрүүлэлт сайтай материалаар хийгдсэн.
- ✓ Өвлийн ажлын хувцас – хүйтний улиралд хамгаалах дулаалгатай, салхи ус нэвтрэхгүй, дулаан хадгалах чадвар өндөртэй.

Ажлын хувцас олголт нь жил бүрийн тогтсон хугацаанд, ажилчдын ажлын онцлог, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцүүлэн хуваарийн дагуу явагддаг. Ингэснээр ажилчид тухайн улирлын нөхцөлд аюулгүй, ая тухтай ажиллах боломжтой болдог.

UT UNUD TUNSH LLC

Өвлийн хувцас олгосон бүртгэл

| Д/д | Овог | Нэр | Албан тушаал | Хүйс | Өвлийн хувцасны размер | | | | | | | | Хүлээн авсан ажилтны гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Өвлийн фоло цамц | | Өвлийн өмд | | Өвлийн куртик | | Өвлийн гутал | | |
| | | | | | Размер | Тоо | Размер | Тоо | Размер | Тоо | Размер | Тоо | Хүлээн авсан огноо: 2025.11.03 |
| 1 | Мөнхдорж | Бумцэнд | Менежер | эр | 52 | 1 | 52 | 1 | 52 | 1 | 42 | 1 | |
| 2 | Эрдэнэдэлгэр | Шинэбаяр | Менежер | эр | 48 | 1 | 48 | 1 | 48 | 1 | 39 | 1 | |
| 3 | Ариунболд | Намуундарь | Гаалийн бүртгэлийн ажилтан | Эм | | | 50 | 1 | 50 | 1 | 39 | 1 | |
| 4 | Саранчимэг | Эрдэнэбаяр | Нярав | Эр | | | 46 | 1 | 46 | 1 | | | |
| 5 | Өсөхбаяр | Бaтeлзий | Пүүны операторэр | Эр | | | 47 | 1 | 47 | 1 | 39 | 1 | |
| 6 | | | | | | | | | | | | | |




Зураг №25. Ажил хувцас, Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, олголтын бүртгэл

8.8 Генераторын үзлэг, засвар үйлчилгээ: Төслийн талбайн цахилгааны найдвартай байдлыг хангах зорилгоор генераторыг нэмэлт эх үүсвэр болгон ашигладаг. Иймээс генераторын хэвийн ажиллагааг хангахын тулд тогтмол үзлэг шалгалт, төлөвлөгөөт үйлчилгээ хийж ажиллаж байна.

8.8.1 Мото цагийн дагуух техникийн үйлчилгээ: Генераторын ашиглалтын мото цагт үндэслэн дараах төлөвлөгөөт үйлчилгээ, шалгалтуудыг тогтмол хийдэг. Үүнд:

- ✓ Тос тосолгооны материалын түвшин шалгах, шаардлагатай бол солих
- ✓ Агаарын болон тосны шүүлтүүрүүдийг цэвэрлэх, солих
- ✓ Генераторын хөргөлтийн системийг шалгах (ус, антифризийн түвшин, хоолойн байдал)
- ✓ Ашиглалтын явцад гарч болзошгүй доголдлыг эрт илрүүлж засвар үйлчилгээний зөвлөмж гаргах

8.8.2 Өдөр тутмын үзлэг : Өдөр бүрийн ээлжийн инженер/механик дараах түргэн үзлэгийг хийж, бүртгэл хөтөлдөг:

- ✓ Генераторын ерөнхий үзлэг (асах/унтрах төлөв, анхааруулах гэрлийн үзүүлэлтүүд)
- ✓ Түлшний түвшин шалгах
- ✓ Хөргөлтийн ус, тосны гоожилт байгаа эсэх
- ✓ Дуу чимээ, доргилтын хэвийн эсэх
- ✓ Генераторын байрласан талбайн аюулгүй байдал (галын хор, газардуулга, салхи шуурганд өртөхгүй байдал)

8.8.3 Найдвартай ажиллагааг хангах арга хэмжээ

- ✓ Үйлчилгээ бүрийн дараа гүйцэтгэлийн тайланг бичиж хадгалдаг
- ✓ Нөөц түлш, шаардлагатай сэлбэг материалыг байнга бэлэн байлгадаг
- ✓ Аюулгүй ажиллагааны зааврын дагуу ажилтан бүр генераторын ойролцоо ажиллахдаа стандартын дагуу ажилладаг.






Генераторын гаднах талбайд ажилчдын аюулгүй байдлыг цахилгааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 метрийн өндөртэй хамгаалалтын хашааг барьж байгуулсан. Ингэснээр генераторын эрчим хүчний өндөр хүчдэл бүхий хэсгийг тусад нь хязгаарлаж, ажилчдыг санамсаргүй ойртохоос хамгаалсан.




Зураг №26. Генератор үзлэгийн хуудасны бүртгэл

## 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Ахуйн хог хаягдал:** Гаалийн хяналтын бүсийн нэгдсэн цэгт хуримтлуулсан энгийн хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын тээврийн хэрэгслээр “Морин заг” төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлэж, зориулалтын ухаж бэлдсэн цэгт нийлүүлэхээр "Батаарын Өлгий" ХХК-тай гэрээ байгуулсан. Усны савыг ангилан ялгаж, цуглуулах 1ширхэг хогын сав шинээр байруулсан. Дотоод орчинд буюу оффисын байруудын гадна болон дотор нийт 25 ширхэг хогийн сав байрлуулсан.




Зураг №27. Хогын сав

**Орчны хог хаягдал түүх**

Төслийн талбайн орчны 50 метр орчимд нийтийн цэвэрлэгээг тогтмол хийж хэвшсэн. Орон нутгаас зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдан ажиллахад байнгын бэлэн ажиллаж байна.




Зураг №28. Нийтийн цэвэрлэгээ

## ДҮГНЭЛТ

"Өнөд Түнш" ХХК нь тайлант онд байгаль орчныг хамгаалах, үйл ажиллагаанаас үүдэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомж, батлагдсан журамд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. Төслийн үндсэн үйл ажиллагаа 2025 оны байдлаар бүрэн хүчин чадлаараа эхлээгүй, бэлтгэл хангах үе шатанд байсан хэдий ч байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр урьдчилан сэргийлэх болон шаардлагатай зохион байгуулалтын ажлуудыг төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж, тайлант хугацаанд ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн болно.